



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ | 2 |
| НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ | 5 |
| 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн: | 5 |
| 1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ: | 10 |
| ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ | 11 |
| 2.1. Нэгдсэн төсвийн орлого: | 11 |
| 2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага: | 15 |
| ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА | 16 |
| 3.1. Гадаад худалдааны эргэлт: | 16 |
| 3.2. Экспорт: | 18 |
| 3.3. Импорт: | 22 |
| ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ | 24 |
| 4.1. Мөнгөний нийлүүлэлт: | 24 |
| 4.2. Гадаад валютын албан нөөц: | 27 |
| 4.3. Төлбөрийн тэнцэл: | 28 |
| ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ | 29 |
| 5.1. Хүн ам, ажил эрхлэлт: | 29 |
| 5.2. Ажилгүйдэл: | 29 |



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



Эдийн засаг 4.8 хувиар өсчээ. 2021 оны жилийн эцэст эдийн засгийн өсөлт 1.6 хувьтай гарч байсан бол 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.8 хувьд хүрч, эдийн засаг 3.2 пунктээр өссөн байна. Үүнд өмнөх жилийн өсөлттэй харьцуулахад уул уурхайн салбар 12.7 пунктээр буурсан хэдий ч хөдөө аж ахуйн салбар 17.5 пункт, аж үйлдвэр, барилга 37.9 пункт, тээвэр ба агуулахын үйлчилгээ 12.2 пунктээр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал буурсан. 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн 17,198.5 тэрбум төгрөг, төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 18,177.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 979.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оноос 1,929.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээ 1.9 хувь болж, өмнөх оноос 4.8 пунктээр буурсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ 1,929.5 тэрбум төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 17,198.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 4,509.1 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 1,244.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 18,177.8 тэрбум төгрөгт хүрч, 656.0 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 96.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оноос 2,547.4 тэрбум төгрөгөөр буюу 16.3 хувиар нэмэгдсэн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 21,245.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 32.1 хувь буюу 5,158.2 сая ам.доллаар өсөж, гадаад худалдааны тэнцэл 3,836.0 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) 29,664.8 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 1,801.3 тэрбум төгрөг буюу 6.5 хувиар өссөн байна. Үүнд төгрөгийн хадгаламж 4.6 хувиар буурсан ч бусад харилцах 1,107.2 тэрбум төгрөг буюу 5.2 хувь, M1 мөнгө 694.1 тэрбум төгрөг буюу 10.7 хувь, гадаад валютын харилцах 22.0 хувиар өссөн нь тус тус нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс өссөн. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 12 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оноос 13.2 хувь, өмнөх сараас 1.0 хувиар өссөн байна.

Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа. 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 2,653.4 сая ам.долларын алдагдалтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 750.9 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оноос 529.3 сая ам.доллаар өссөн байна.

Үнэт цаасны арилжаа буурчээ. Үнэт цаасны арилжаагаар 2022 онд 551.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 600.2 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оноос гүйлгээ 616.4 (52.8%) тэрбум төгрөгөөр, арилжсан үнэт цаас 91.3 (13.2%) сая ширхгээр буурсан үзүүлэлт болж байна.

Гадаад валютын ханш өссөн. 2022 оны жилийн эцэст төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн сарын дундаж 3,431.3 төгрөг болж, өмнөх оноос 582.3 төгрөгөөр суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 491.7 төгрөг болж өмнөх **оноос 44.3 төгрөгөөр суларчээ.**

Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцэст 1,123.5 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны эцсээс 190.9 тэрбум төгрөг буюу 20.5 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.1 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ буурчээ. 2022 оны эцэст 2.0 их наяд төгрөг болж, өнгөрсөн оноос 54.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.2 хувийг эзэлж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ:

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 28.4 их наяд төгрөг болж, эдийн засаг өнгөрсөн оноос 4.8 хувиар тэлсэн байна.

2021 оны эхний улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч их уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2022 оны эхний улирал хүртэлх хугацаанд саарч, 2022 оны 2 дугаар улирлаас өсөж, 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.8 хувийн өсөлттэй гарлаа. Зураг 1-д 2016-2022 оны жилийн эцсийн байдлаарх ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

Ийнхүү эдийн засгийн өсөлт удааширч, улмаар уналт бий болоход гадаад болон дотоодын томоохон хүчин зүйлс сэргээр нөлөөлсөн байна. Тухайлбал, дотоод хүчин зүйлсийн хувьд 2021 онд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал үргэлжилж Монгол Улсад хэд хэдэн удаагийн хатуу хөл хорио тогтоосон нь нөлөөлсөн бол гадаад нөхцөл байдлын хувьд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор БНХАУ хилээ түр хаасан, 2022 оны эхэнд ОХУ, Украин улсын хооронд дайн гарсан, зарим улс орнуудын Төв банкнаас мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эхэлсэн, тээвэр логистик, хангамжийн сүлжээнд доголдол үүссэн, хүнсний хомсдол бий болсон зэрэг гадаад орчны тодорхой бус байдал голлон нөлөөлжээ.

График 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 52.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 21.4 хувь буюу 9.3 их наяд төгрөгөөр өссөн бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 28.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.8 хувь буюу 1.3 их наяд төгрөгөөр өссөн байна.

Нэгтгэсэн дүнгээр авч үзвэл, 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр бодит ДНБ-ий өсөлтөд уул уурхайн салбарын оролцоо 1.6 хувийн сөрөг, бусад салбарын оролцоо 0.1-1.7 хувийн эерэг нөлөөг үзүүлсэн байна. Дэлгэрүүлбэл, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, барилга, цахилгаан, тээвэр, үйлчилгээ болон бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт ДНБ-ий өсөлтийн 5.1 нэгж хувийг бүрдүүлжээ.


Уул уурхайгаас бусад эдийн засгийн салбаруудын өсөлтийг дурдвал, хөдөө аж ахуйн салбар 12.0 хувь, мэдээлэл холбоо 11.5 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 11.5 хувь, барилгын салбар 7.9 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 6.9 хувь, боловсруулах үйлдвэрлэл 6.3 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 4.9 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалт 3.3 хувь, бусад үйлчилгээ 4.9 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 1. ДНБ-ий бодит өсөлт, салбараар /хувиар/

| Үзүүлэлт | 2021 | 2022 | 2020 | | | | 2021 | | | | 2022 | | | |
|--|-------|-------|-------|-------|-------|-------|------|------|-------|-------|-------|-------|-------|-------|
| | | | I | II | III | IV | I | II | III | IV | I | II | III | IV |
| Эдийн засгийн өсөлтийн өөрчлөлт, салбараар /хувь/ | | | | | | | | | | | | | | |
| ДНБ-ий бодит өсөлт | 1.6 | 4.8 | -10.1 | -9 | -6.7 | -4.6 | 14.8 | 6.3 | 3.7 | 1.6 | -3.9 | 1.9 | 3.7 | 4.8 |
| Хөдөө аж ахуй ойн аж ахуй загас барилт ан агнуур | -5.5 | 12 | 12 | 12.4 | 10.8 | 5.8 | -4.5 | -4.6 | -4.7 | -5.5 | 11.3 | 11.3 | 10.2 | 12 |
| Уул уурхай, олборлолт | 1.7 | -11.9 | -32.9 | -31.5 | -22.1 | -9.9 | 38.5 | 23.5 | 10.9 | 0.8 | -37.5 | -28.8 | -17.3 | -11.9 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 0.3 | 6.3 | 1.2 | -5.9 | -5.8 | 3.4 | 23.8 | 11.8 | 5.3 | -0.9 | -10 | -2.2 | 2.1 | 6.3 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 9.4 | 3.3 | 5.5 | 2.3 | 1.1 | 1.8 | 6.8 | 9.2 | 9.1 | 9.4 | 6.1 | 5.2 | 4.4 | 3.3 |
| Барилга | -32.7 | 7.9 | 13 | -1.8 | -1.9 | -3.2 | -0.4 | -34 | -30.2 | -22.8 | -29.9 | -8.7 | 3.7 | 7.9 |
| Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ | 9.4 | 6.9 | -13.6 | -15.1 | -14.8 | -12.5 | 6.1 | 5.2 | 5.1 | 5.8 | 7.3 | 12.2 | 11.3 | 6.9 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | -16.7 | 4.9 | -31 | -32.2 | -23.6 | -18.2 | 18.7 | 10.1 | 0.6 | -7.3 | -33.7 | -22.5 | -2.4 | 4.9 |
| Мэдээлэл, холбоо | 12.2 | 11.5 | 5.2 | 5.5 | 5.5 | 5.2 | 13.7 | 19.6 | 17.8 | 20.7 | 14.9 | 12.5 | 8.7 | 11.5 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 4.6 | 4.9 | -3 | -4.3 | -3 | -2.6 | 0.8 | 0.3 | 2 | 3.8 | 3.8 | 4.6 | 3.9 | 4.9 |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 12.2 | 11.5 | -8.1 | -12.4 | -8.8 | -9.4 | 46.4 | 23.5 | 14.9 | 12.2 | 9.8 | 11.8 | 11.9 | 11.5 |


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 2. Нэрлэсэн ДНБ, өөрчлөлт /оны үнээр, их наяд төгрөгөөр/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Бодит ДНБ, өөрчлөлт /2015 оны зэрэгцүүлэх үнээр, их наяд төгрөгөөр/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны жилийн эцэст эдийн засгийн өсөлт 1.6 хувьтай гарч байсан бол 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.8 хувьд хүрч, эдийн засаг 3.2 пунктээр өссөн байна.

2021 оны жилийн эцэст эдийн засгийн өсөлт 1.6 хувьтай гарч байсан бол 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.8 хувьд хүрч, эдийн засаг 3.2 нэгж хувиар өссөн байна. Эдийн засаг 3.2 нэгж хувиар өсөхөд өмнөх жилийн өсөлтөөс уул уурхай, олборлолт 12.7 нэгж хувиар буурсан хэдий ч хөдөө аж ахуй 17.5 нэгж хувь, аж үйлдвэр, барилга 37.9 нэгж хувь, тээвэр ба агуулахын үйлчилгээ 12.2 нэгж хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо, нэгж хувиар

| Салбараар | Жилийн эцсийн байдлаар Өөрчлөлт | | Өөрчлөлт |
|-----------------------------|---------------------------------|---------|----------|
| | 2021-IV | 2022-IV | |
| ДНБ-ий бодит өсөлт | 1.6 | 4.8 | 3.2 |
| Хөдөө аж ахуй | -5.5 | 12.0 | 17.5 |
| Уул уурхай, олборлолт | 0.8 | -11.9 | -12.7 |
| Аж үйлдвэр, барилга | -23.7 | 14.2 | 37.9 |
| Барилга | -22.8 | 7.9 | 30.7 |
| Боловсруулах үйлдвэрлэл | -0.9 | 6.3 | 7.2 |
| Үйлчилгээ | 39.7 | 26.6 | -13.1 |
| Тээвэр ба агуулах | -7.3 | 4.9 | 12.2 |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 12.2 | 11.5 | -0.7 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ:

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2022 оны жилийн эцэст 53.5 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 19.7 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 28.3 их наяд төгрөг болж өнгөрсөн оноос 4.8 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр, өссөн дүнгээр /тэрбум төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2019-IV | 2020-IV | 2021-IV | 2022-IV | Өөрчлөлт (хувиар) |
|---|----------|----------|----------|----------|----------------------|
| ДНБ | 37,839.2 | 37,883.0 | 44,702.7 | 53,505.3 | 19.7 |
| Эцсийн хэрэглээ | 26,627.5 | 28,570.0 | 29,580.8 | 34,964.3 | 18.2 |
| Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ | 21,667.6 | 22,648.6 | 23,085.5 | 27,611.6 | 19.6 |
| Төрийн байгууллагын хэрэглээ | 4,960.0 | 5,921.5 | 6,495.3 | 7,352.7 | 13.2 |
| Хөрөнгийн нийт хуримтлал | 13,467.7 | 8,383.4 | 15,993.2 | 21,484.8 | 34.3 |
| Үндсэн хөрөнгийн хуримтлал | 10,588.7 | 8,830.8 | 11,688.3 | 13,593.7 | 16.3 |
| Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал | 2,879.0 | -447.4 | 4,304.9 | 7,891.1 | 83.3 |
| Цэвэр экспорт | -2,256.0 | 929.6 | -871.3 | -2,943.8 | 237.9 |
| Бараа, үйлчилгээний экспорт | 22,407.3 | 21,595.7 | 25,501.2 | 36,843.8 | 44.5 |
| Бараа, үйлчилгээний импорт | 24,663.3 | 20,666.1 | 26,372.5 | 39,787.6 | 50.9 |


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 4. Эцсийн ашиглалтын аргаар ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өссөн дүнгээр /тэрбум төгрөгөөр/

| Бүрэлдэхүүн | 2019-IV | 2020-IV | 2021-IV | 2022-IV | Өөрчлөлт /хувиар/ |
|---|----------|----------|----------|----------|----------------------|
| ДНБ | 27,836.8 | 26,622.7 | 27,054.7 | 28,323.9 | 4.8 |
| Эцсийн хэрэглээ | 22,060.4 | 23,051.2 | 22,438.7 | 23,990.9 | 6.9 |
| Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ | 17,787.1 | 18,153.2 | 17,090.9 | 18,351.9 | 7.4 |
| Төрийн байгууллагын хэрэглээ | 4,273.3 | 4,898.0 | 5,347.8 | 5,639.0 | 5.4 |
| Хөрөнгийн нийт хуримтлал | 11,057.3 | 6,561.4 | 11,857.7 | 13,696.2 | 15.5 |
| Үндсэн хөрөнгийн хуримтлал | 8,684.8 | 6,852.5 | 8,064.1 | 8,086.0 | 0.3 |
| Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал | 2,372.4 | -291.1 | 3,793.6 | 5,610.2 | 47.9 |
| Цэвэр экспорт | -5,280.8 | -2,989.8 | -7,241.7 | -9,363.2 | 29.3 |
| Бараа, үйлчилгээний экспорт | 14,391.7 | 13,634.0 | 11,638.7 | 15,277.9 | 31.3 |
| Бараа, үйлчилгээний импорт | 19,672.5 | 16,623.9 | 18,880.4 | 24,641.1 | 30.5 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 4. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар /их наяд төгрөгөөр/



2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засаг 4.8 хувиар өсөхөд өрхийн хэрэглээ 7.4 хувиар, хөрөнгийн нийт хуримтлал 15.5 хувиар, экспорт 31.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 5. ДНБ-ий бодит өсөлт, салбараар /хувиар/

| Бүрэлдэхүүн | 2020 | | | | 2021 | | | | 2022 | | | |
|---|-------|-------|--------|--------|-------|-------|----------|----------|-------|-------|------|------|
| | I | II | III | IV | I | II | III | IV | I | II | III | IV |
| ДНБ | -7.3 | -7.5 | -6.0 | -4.4 | 15.1 | 6.2 | 3.4 | 1.6 | -3.8 | 1.9 | 3.7 | 4.8 |
| Эцсийн хэрэглээ | 7.6 | 7.0 | 7.2 | 4.5 | -11.4 | -8.9 | -8.3 | -2.7 | 7.6 | 6.4 | 6.5 | 6.9 |
| Өрх | 6.6 | 6.3 | 6.0 | 2.1 | -11.6 | -9.2 | -8.4 | -5.9 | 8.8 | 6.9 | 7.2 | 7.4 |
| Засгийн газар | 11.7 | 9.8 | 12.5 | 14.6 | -10.6 | -7.7 | -8.0 | 9.2 | 2.3 | 4.3 | 3.6 | 5.4 |
| Хөрөнгийн нийт хуримтлал | -10.3 | -25.2 | -30.6 | -40.7 | 29.2 | 44.7 | 78.2 | 80.7 | 15.4 | 43.3 | 20.1 | 15.5 |
| Үндсэн хөрөнгийн хуримтлал | -15.4 | -20.7 | -14.6 | -21.1 | 12.2 | 12.6 | 2.8 | 17.7 | -7.3 | 2.2 | 2.0 | 0.3 |
| Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал | 290.5 | -54.6 | -131.6 | -112.3 | 249.4 | 412.9 | -1,210.6 | -1,403.0 | 109.1 | 146.6 | 48.8 | 47.9 |
| Цэвэр экспорт | 43.2 | 25.6 | 4.3 | -43.4 | -47.3 | -9.4 | 55.0 | 142.2 | 81.6 | 93.5 | 40.1 | |
| Экспорт | -42.6 | -26.8 | -19.6 | -5.3 | 81.9 | 14.0 | -9.0 | -14.6 | -25.7 | -16.0 | 13.3 | 31.3 |
| Импорт | -14.5 | -13.6 | -14.3 | -15.5 | 11.0 | 5.4 | 8.5 | 13.6 | 2.3 | 18.3 | 23.8 | 30.5 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2. Нэг хүнд ногдох ДНБ

Бүтээмжийг нэг хүнд ногдох бодит ДНБ-ээр илэрхийлдэг. Монгол Улсын хувьд, Үндэсний статистикийн хорооноос 2015 оноос хойш улирал бүр уул уурхай, аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарын бүтээмжийн талаарх статистик тоон мэдээллийг нийтэлдэг болсон. Бүтээмжийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр нэг ажиллагчид ногдох ДНБ-ээр илэрхийлэн тооцоолж байна.

Бүтээмж 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6.6 сая төгрөг болж, өмнөх оноос 5.3 хувиар буюу 331.1 мянган төгрөгөөр өссөн байна. Салбараар нь авч үзвэл хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 14.4 хувь, үйлчилгээний салбар 6.9 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 5.0 хувиар тус тус нэмэгдсэн боловч уул уурхайн салбарын бүтээмж 10.0 хувь буюу 1.9 сая төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 6. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт /мянган төгрөгөөр/

| Бүрэлдэхүүн | 2022 оны IY улирлын байдлаар | | | | Өөрчлөлт 2022/2021 | |
|-------------------------------|------------------------------|----------|----------|----------|-----------------------|-------|
| | 2019 | 2020 | 2021 | 2022 | Дүн | Хувь |
| Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин | 6,112.1 | 6,538.6 | 6,265.9 | 6,597.0 | 331.1 | 5.3 |
| Хөдөө аж ахуй | 2,893.5 | 2,990.7 | 2,639.2 | 3,018.4 | 379.2 | 14.4 |
| Уул уурхай, олборлолт | 20,154.9 | 30,283.7 | 19,940.6 | 17,946.2 | -1,994.4 | -10.0 |
| Аж үйлдвэр, барилга | 7,856.7 | 9,494.2 | 8,451.8 | 8,872.3 | 420.5 | 5.0 |
| Үйлчилгээ | 5,103.3 | 4,822.6 | 5,244.0 | 5,606.9 | 362.9 | 6.9 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн 17,198.5 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 18,177.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 979.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 17,198.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 4,509.1 тэрбум төгрөг буюу 35.5 хувиар, төсвийн нийт зарлага 2,579.7 тэрбум төгрөг буюу 16.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Монгол Улсын нэгдсэн төсөв /тэрбум төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | | Гүйцэтгэл | | Биелэлтийн хувь | Өөрчлөлт(+/-) | |
|--|------------|----------|-----------|----------|-----------------|---------------|---------|
| | 1 | 2 | 3 | (3:1) | | (3-2) | (3-2)/2 |
| | 2022.12 | 2021.12 | 2022.12 | Гүйц/төл | Дүн | Хувь | |
| Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 15,954.5 | 12,689.4 | 17,198.5 | 107.8 | 4,509.1 | 35.5 | |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 18,833.8 | 15,598.1 | 18,177.8 | 96.5 | 2,579.7 | 16.5 | |
| Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл | -2,879.3 | -2,908.8 | -979.3 | 34.0 | 1,929.5 | -66.3 | |
| ДНБ, оны үнээр | | 43,555.5 | 52,867.4 | | 9,311.9 | | |
| Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ /хувиар/ | | 6.7 | 1.9 | | -4.8 | | |

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 979.3 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 107.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээ 1.9 хувь болж өмнөх оноос 4.8 нэгж хувиар буурсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ 1,929.5 тэрбум төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 17,198.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 35.5 хувиар буюу 4,509.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 1,244.0 тэрбум төгрөг буюу 7.8 хувиар давж биелсэн байна.

Тайлант хугацааны гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 7.8 хувь буюу 1,244.0 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 8.5 хувь буюу 274.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол орон нутгийн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 5.2 хувь буюу 173.8 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 15.6 хувь буюу 226.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр орон нутгийн төсөв 15.0 хувь буюу 553.8 тэрбум төгрөгөөр буурсан бол улсын төсөв 12.7 хувь буюу 1,148.4 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 28.1 хувь буюу 768.1 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 22.2 хувь буюу 222.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн орлогын 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр, төсвийн шатлалаар /тэрбум төгрөгөөр/

| Ангилал | Улсын төсөв | | Орон нутгийн төсөв | | НДС Өөрчлөлт (+/-) | | ЭМДС | |
|--|-------------|----------|--------------------|---------|--------------------|---------|---------|---------|
| | Төл. | Гүйц. | Төл. | Гүйц. | Төл. | Гүйц. | Төл. | Гүйц. |
| Нийт орлого ба тусламжийн дүн | 9,969.9 | 11,596.1 | 3,312.7 | 3,138.8 | 3,225.7 | 3,500.2 | 1,450.7 | 1,224.7 |
| Тогтворжуулалтын сан | 751.7 | 1,394.6 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 9,218.2 | 10,201.5 | 3,312.7 | 3,138.8 | 3,225.7 | 3,500.2 | 1,450.7 | 1,224.7 |
| Татварын орлого | 7,468.0 | 8,928.0 | 2,499.9 | 2,472.8 | 2,380.0 | 2,656.3 | 1,450.7 | 1,224.7 |
| Татварын бус орлого | 1,750.2 | 1,273.5 | 812.7 | 666.0 | 845.8 | 843.9 | 0.0 | 0.0 |

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо


Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 90.5 хувийг татварын орлого, 9.5 хувийг татварын бус орлого эзэлж байна.

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр Тогтворжуулалтын санд 751.7 тэрбум, Ирээдүйн өв санд 1,461.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс тус сангуудад төвлөрүүлэх орлого биелсэн. Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого 85.5 хувь буюу 642.9 тэрбум төгрөгөөр, харин Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлого 8.9 хувь буюу 129.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Нэгдсэн төсвийн татварын орлого 15,568.3 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 12.3 хувиар буюу 1,710.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн, харин өмнөх оноос 37.8 хувь буюу 4,268.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлого: Татварын орлогын 25.4 хувийг орлогын албан татвар, 19.4 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.5 хувийг хөрөнгийн албан татвар, 25.2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 5.4 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 8.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 14.7 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

График 5. Татварын орлогын бүтэц /хувиар/



Эх сурвалж: Сангийн яам

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого төлөвлөснөөс 12.3 хувь буюу тэрбум төгрөгөөр давж биелэхэд орлогын албан татвар 26.3 хувь (822.8 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 12.1 хувь (421.8 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 19.4 хувь (210.3 тэрбум төгрөг)-аар тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.


Өнгөрсөн онтой харьцуулахад 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого 37.8 хувь буюу 4,268.4 тэрбум төгрөгөөр өсөхөд нийгмийн даатгалын орлого 32.4 хувь (740.9 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 16.7 хувь (33.7 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 38.1 хувь (1,080.9 тэрбум төгрөг), онцгой албан татвар 2.5 хувь (20.8 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 16.6 хувь (2.8 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 37.6 хувь (353.3 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 163.3 хувь буюу (1,415.3 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого 1,630.2 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 218.7 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 466.7 тэрбум төгрөг буюу 22.3 хувиар дутуу биелжээ.

Татварын бус орлого: Татварын бус орлогын 81.4 хувийг нийтлэг татварын бус орлого, 18.4 хувийг тусламжийн орлого, 0.2 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 36.0 хувийг хувьцааны ногдол ашгийн орлого, 5.2 хувийг хүүгийн орлого, 8.6 хувийг торгуулийн орлого, 26.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.4 хувийг түрээсийн орлого, 12.1 хувийг газрын тосны орлого, 1.2 хувийг навигацыйн орлого эзэлсэн бол 9.0 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

График 6. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.9 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, гадаад хандив тусламжийн орлого 4.4 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Харин нийтлэг татварын бус орлогоос хүүгийн орлого 3.6 тэрбум төгрөг болж давж биелсэн бол, хувьцааны ногдол ашиг 117.4 тэрбум төгрөг, торгуулийн орлого 11.4 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 20.6 тэрбум төгрөг, газрын тосны орлого 54.5 тэрбум төгрөг, навигацыйн орлого 134.0 тэрбум төгрөг, бусад орлого 130.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 18,833.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 96.5 хувийг зарлагдаж 656.0 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өмнөх онтой харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 2,547.4 тэрбум төгрөг буюу 16.3 хувиар өсөж 18,177.8 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн зарлага

/тэрбум төгрөгөөр/

| Үзүүлэлт | Гүйцэтгэл /2021/ | 2022 оны урьдчилсан гүйцэтгэл Орон нутгийн төсөв НДС | | | |
|--|---------------------|---|--------------|-------------|--------------|
| | | Төл. | Гүйц. | Хувь | Зөрүү |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 15,630.4 | 18,833.8 | 18,177.8 | 96.5 | -656.0 |
| Нийт зарлага | 15,786.2 | 19,081.9 | 18,025.3 | 94.5 | -1,056.5 |
| Урсгал зардал | 12,804.0 | 14,823.0 | 14,212.2 | 95.9 | -610.8 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 4,702.0 | 410,967.0 | 3,761.4 | 91.5 | -348.3 |
| Хүү | 835.7 | 891.2 | 816.4 | 91.6 | -74.7 |
| Татаас | 453.7 | 578.2 | 537.1 | 92.9 | -41.2 |
| Урсгал шилжүүлэг | 6,812.6 | 9,243.9 | 9,097.3 | 98.4 | -146.6 |
| Хөрөнгийн зардал | 2,982.2 | 4,258.9 | 3,813.1 | 89.5 | -445.7 |
| Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | -155.8 | -248.0 | 152.5 | -61.5 | 400.5 |

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 78.2 хувь буюу 14,212.2 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 64.0 хувийг урсгал шилжүүлэг, 26.5 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 5.7 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.8 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,408.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 940.6 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 19.3 тэрбум төгрөгөөр буурсан ч, татаас 83.4 тэрбум, урсгал шилжүүлэг 2,284.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 308.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА**3.1. Гадаад худалдааны эргэлт:**

2022 оны жилийн эцсийн байдлаар манай улс дэлхийн 161 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 21,245.0 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 5,158.2 сая ам.доллар буюу 32.1 хувиар өссөн байна.

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр экспорт импортын дүнгээс 3,836.0 сая ам.доллаар давж, экспортын худалдаа 12,540.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 35.7 хувь буюу 3,299.0 сая ам.доллаар өссөн, мөн импорт 8,704.0 сая ам.долларт хүрч 27.2 хувь буюу 1,859.0 сая ам.доллаар нэмэгдсэн нь гадаад худалдааны ашгийг 60.1 хувь буюу 1,440.0 сая ам.доллаар нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 10. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

| Үзүүлэлт | Жил бүрийн нэгдүгээр улирал | | | | | Өөрчлөлт | |
|--------------------|-----------------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|----------------|-------------|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | Дүн | Хувь |
| Нийт эргэлт | 12,887.0 | 13,747.0 | 12,875.0 | 16,087.0 | 21,245.0 | 5,158.0 | 32.1 |
| -Экспорт | 7,012.0 | 7,620.0 | 7,576.0 | 9,241.0 | 12,540.0 | 3,299.0 | 35.7 |
| -Импорт | 5,875.0 | 6,128.0 | 5,299.0 | 6,846.0 | 8,704.0 | 1,859.0 | 27.2 |
| Тэнцэл | 1,137.0 | 1,492.0 | 2,277.0 | 2,396.0 | 3,836.0 | 1,440.0 | 60.1 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаад худалдааны тэнцэл: Гадаад худалдааны тэнцэл сүүлийн 5 жил дараалан ашигтай гарчээ. 2022 оны жилийн эцсийн байдлаар гадаад худалдааны тэнцэл 3,836.0 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оноос гадаад худалдааны ашиг 1,440.0 сая ам.доллар буюу 60.1 хувиар өсөхөд импортын 1,859.0 сая ам.долларын, экспортын 3,299.0 сая ам.долларын өсөлт тус тус нөлөөлсөн байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй экспорт нийт экспортын орлогын 99.4 хувь, валютын төлбөртэй импорт нь нийт импортын худалдааны 95.8 хувийг тус тус эзэлж байна. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 4,130.7 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оноос 1,508.4 сая ам.доллаар өссөн байна. Валютын төлбөртэй барааны тэнцэл өсөхөд валютын төлбөртэй экспорт 3,286.8 сая ам.доллаар, валютын төлбөртэй импорт 1,778.4 сая ам.доллаар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 11. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл


/сая.ам.доллаар/

| Үзүүлэлт | Жилээр | | Өөрчлөлт | |
|--|----------------|-----------------|----------------|-------------|
| | 2021 он | 2022 он | Дүн | Хувь |
| А.Экспорт | 9,241.1 | 12,540.4 | 3,299.3 | 35.7 |
| Валютын төлбөртэй бараа | 9,179.9 | 12,466.7 | 3,286.8 | 35.8 |
| Валютын төлбөртэй экспортын нийт экспортод эзлэх хувь(%) | 99.3 | 99.4 | 0.1 | |
| Б.Импорт | 6,845.5 | 8,704.4 | 1,859.0 | 27.2 |
| Валютын төлбөртэй бараа | 6,557.7 | 8,336.1 | 1,778.4 | 27.1 |
| Валютын төлбөртэй импортын нийт импортод эзлэх хувь(%) | 95.8 | 95.8 | 0.0 | 0.0 |
| Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл | 2,622.2 | 4,130.7 | 1,508.5 | 57.5 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2022.12)-аар тооцон үзэв. 2013 онд Оюутолгойн уурхайн төсөл эхэлж, олборлолт, борлуулалт хийснээр экспортын тоо хэмжээ 2014-2015 онуудад өссөн. 2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оноос хойш гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

График 7. Гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт болон импортын худалдаанд хөрш ОХУ болон БНХАУ томоохон хувийг эзэлдэг. Тухайлбал, 2022 байдлаар хөрш орнууд нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 76.8 хувь, экспортын 85.0 хувь, импортын 65.0 хувийг тус тус эзэлж байна. 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 64.4 хувь буюу 13,608.3 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, мөн 13.1 хувь буюу 2,703.1 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийсэн байна. Харин бусад улс оронтой хийсэн гадаад худалдаа нь нийт бараа эргэлтийн 22.5 хувийг эзэлж байна. БНХАУ нийт экспортын 89.1 хувь /10.6 тэрбум ам.доллар/, нийт импортын 33.6 хувь /3.04 тэрбум ам.доллар/-ийг эзэлж байгаа бол ОХУ-ын хувьд нийт экспортын 0.9 хувь, нийт импортын 28.2 хувь /2.6 тэрбум ам.доллар/-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

| Улс орон | Төрөл | Эзлэх хувь 2022 он | Жил бүрийн нэгдүгээр улирал | | | | Өөрчлөлт (+/-) | |
|----------|-------------|--------------------|-----------------------------|----------|----------|----------|-----------------|-------|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2022.12/2021.12 | |
| | | | Зөрүү | | Хувь | | | |
| ОХУ | Нийт эргэлт | 13.1 | 1,798.0 | 2,547.9 | 2,068.0 | 2,703.1 | 635.1 | 30.7 |
| | Экспорт | 0.9 | 68.1 | 57.3 | 112.8 | 91.6 | -21.2 | -18.8 |
| | Импорт | 28.2 | 1,729.9 | 2,490.6 | 1,955.2 | 2,611.5 | 656.3 | 33.6 |
| | Тэнцэл | | -1,661.8 | -2,433.3 | -1,842.4 | -2,519.8 | -677.4 | 36.8 |
| БНХАУ | Нийт эргэлт | 64.4 | 8,850.6 | 7,403.8 | 10,123.8 | 13,608.3 | 3,484.5 | 34.4 |
| | Экспорт | 89.1 | 6,789.8 | 5,493.6 | 7,633.2 | 10,565.9 | 2,932.7 | 38.4 |
| | Импорт | 33.6 | 2,060.8 | 1,910.2 | 2,490.6 | 3,042.4 | 551.8 | 22.2 |
| | Тэнцэл | | 4,729.0 | 3,583.4 | 5,142.6 | 7,523.5 | 2,381.0 | 46.3 |
| Бусад | Нийт эргэлт | 22.5 | 3,098.7 | 2,923.6 | 3,894.8 | 4,933.4 | 1,038.6 | 26.7 |
| | Экспорт | 10.0 | 761.9 | 2,025.5 | 1,495.2 | 1,882.8 | 387.7 | 25.9 |
| | Импорт | 38.1 | 2,336.8 | 898.1 | 2,399.7 | 3,050.6 | 650.9 | 27.1 |
| | Тэнцэл | | -1,574.9 | 1,127.4 | -904.5 | -1,167.7 | -263.2 | 29.1 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

3.2. Экспорт:

Экспортын худалдаа 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 12,540.0 сая ам.доллар болж, Коронавирус халдвар /Ковид-19/-ын цар тахлаас өмнөх буюу 2019 онтой харьцуулахад 4,920.0 сая ам.доллар буюу 64.6 хувиар өссөн бол 2021 оноос 5,158.2 сая ам.доллар буюу 32.1 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 10,542.0 сая ам.доллар болж, өмнөх оноос 3,031.6 сая ам.доллар буюу 40.4 хувиар өссөн, харин эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,998.4 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 267.7 сая ам.доллар буюу 15.5 хувиар өссөн байна. Эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 91.9 хувь болж, өмнөх оноос 10.6 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь эрдсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 13. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт


/сая ам.доллар/

| Үзүүлэлт | Он | | | | | Өөрчлөлт | | Нийт экспортод эзлэх хувь |
|--------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|-----------------|----------------|-------------|---------------------------|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | Дүн | Хувь | |
| Эрдсийн бүтээгдэхүүний экспорт | 6,070.3 | 6,377.5 | 5,256.0 | 7,510.4 | 10,542.0 | 3,031.6 | 40.4 | 91.9 |
| Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт | 941.4 | 1,242.3 | 2,320.3 | 1,730.7 | 1,998.4 | 267.7 | 15.5 | 8.1 |
| Нийт экспорт | 7,011.8 | 7,619.8 | 7,576.3 | 9,241.1 | 12,540.4 | 3,299.3 | 35.7 | 100 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр экспортын орлогын 51.8 хувийг нүүрс, 21.8 хувийг зэсийн баяжмал, 8.9 хувийг боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспортын орлого эзэлж байна.


График 8. Гол нэр төрлийн барааны экспорт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдрийн экспортын орлого, тоо хэмжээ болон үнийн өөрчлөлтийг бүтээгдэхүүн бүрээр харууллаа. Эдгээр эрдсийн бүтээгдэхүүний 2022 оны зэсийн хилийн дундаж үнэ 2057.9 ам.дол/тн, нүүрсний хилийн дундаж үнэ 252.8 ам.дол/тн, төмрийн хилийн дундаж үнэ 90.5 ам.дол/тн байгаа нь экспортын орлого өсөхөд нөлөөлсөн байна.

График 9. Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 10. Нүүрсний экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 11. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 14. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

| Барааны төрөл | Хэмжих нэгж | Он | | | | Өмнөх оноос | |
|---|-------------|---------|---------|---------|---------|-------------|-------|
| | | 2019 | 2020 | 2021 | 2022 | Дүн | Хувь |
| Адууны мах | мян.тн | 30.8 | 17.7 | 7.0 | 6.9 | 0.0 | -0.4 |
| Богийн өлөн гэдэс | тн | 419.5 | 503.1 | 642.9 | 632.4 | -10.5 | -1.6 |
| Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт | тн | 9.1 | 30.5 | 17.2 | 19.7 | 2.5 | 14.3 |
| Зэсийн баяжмал | мян.тн | 1,403.6 | 1,395.1 | 1,282.5 | 1,453.3 | 170.8 | 13.3 |
| Жоншны хүдэр ба баяжмал | мян.тн | 699.4 | 678.9 | 644.3 | 387.7 | -256.6 | -39.8 |
| Төмрийн хүдэр, баяжмал, пирит | сая.тн | 8.4 | 8.2 | 7.1 | 4.7 | -2.4 | -33.4 |
| Цайрын баяжмал | мян.тн | 134.8 | 134.1 | 112.6 | 141.2 | 28.6 | 25.4 |
| Тунгаасан зэс ба хайлш | мян.тн | 11.9 | 9.6 | 9.8 | 10.0 | 0.2 | 1.7 |
| Хонь, хурганы боловсруулсан арьс буюу шеврет | сая.дм2 | 54 | 49.2 | 66.3 | 0.1 | 0.0 | 18.9 |
| Ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро | сая.дм2 | 120.9 | 85.2 | 77 | 0.1 | 0.0 | -2.0 |
| Хонины самнаагүй ноос | мян.тн | 14.8 | 8.5 | 5.4 | 17.6 | 12.2 | 227.9 |
| Бохир ноолуур | мян.тн | 5.7 | 6.3 | 6.0 | 6.4 | 0.4 | 6.4 |
| Самнасан ноолуур | тн | 507.2 | 260 | 424 | 0.9 | 0.4 | 102.1 |
| Нүүрс | сая.тн | 36.6 | 28.7 | 16.1 | 31.8 | 15.7 | 97.1 |
| Боловсруулаагүй нефть | сая.барр | 6.5 | 4.1 | 4.3 | 2.6 | -1.7 | -40.1 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 15. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

| Барааны төрөл | Он | | | | Өмнөх оноос | |
|---|-------------|-------------|-------------|-------------|-------------|------------|
| | 2019 | 2020 | 2021 | 2022 | Дүн | Хувь |
| Адууны мах | 57.7 | 33.3 | 14.4 | 21.1 | 6.6 | 45.8 |
| Богийн өлөн гэдэс | 8.5 | 8.9 | 15.3 | 15.9 | 0.6 | 4.0 |
| Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт | 418.4 | 1,787.7 | 1,004.5 | 1,127.4 | 122.9 | 12.2 |
| Зэсийн баяжмал | 1,795.9 | 1,778.0 | 2,899.9 | 2,734.8 | -165.0 | -5.7 |
| Жоншны хүдэр ба баяжмал | 205.3 | 156.3 | 144.0 | 110.5 | -33.5 | -23.2 |
| Төмрийн хүдэр, баяжмал, пирит | 576.6 | 639.7 | 952.2 | 391.0 | -561.2 | -58.9 |
| Цайрын баяжмал | 189.0 | 167.7 | 176.4 | 283.3 | 106.9 | 60.6 |
| Тунгаасан зэс ба хайлш | 68.9 | 59.3 | 88.5 | 82.6 | -6.0 | -6.7 |
| Хонь, хурганы боловсруулсан арьс буюу шеврет | 1.2 | 1.0 | 1.3 | 1.4 | 0.0 | 2.6 |
| Ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро | 4.0 | 3.1 | 2.4 | 1.6 | -0.8 | -33.9 |
| Хонины самнаагүй ноос | 20.4 | 9.0 | 5.4 | 16.5 | 11.1 | 206.2 |
| Бохир ноолуур | 283.3 | 185.3 | 253.6 | 307.7 | 54.0 | 21.3 |
| Самнасан ноолуур | 45.3 | 16.9 | 39.9 | 93.1 | 53.1 | 133.1 |
| Нүүрс | 3,078.8 | 2,126.6 | 2,779.5 | 6,502.7 | 3,723.3 | 134.0 |
| Боловсруулаагүй нефть | 366.7 | 150.9 | 273.4 | 241.8 | -31.5 | -11.5 |
| Нийт экспортод эзлэх хувь | 93.4 | 94.2 | 93.6 | 95.1 | | 1.5 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оноос 3,031.6 сая ам.доллар буюу 40.4 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 31.8 сая тонн нүүрс экспортолж, 6,502.7 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оноос нүүрсний үнэ 204.4 ам.доллар/тн болж, 1.2 дахин өссөн, мөн экспортын биет хэмжээ 15.7 сая тонноор өссөн зэрэг нь нүүрсний экспортын орлого 3,723.3 сая ам.доллар буюу 134 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.

Цайрын баяжмал: 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 141.2 мянган тоннд хүрч, 283.3 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Нэг тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 28.1 хувиар нэмэгдсэн мөн цайрын баяжмалын биет хэмжээ 25.4 хувь буюу 28.6 мянган тонноор өссөн зэрэг нь цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оноос 60.6 хувь буюу 106.9 сая ам.доллараар өсөхөд нөлөөлжээ.

Алт: 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 19.7 тонн алт экспортлож, экспортын орлого 1,127.4 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 12.2 хувиар нэмэгдсэн байна. Экспортолсон алтны үнэ өмнөх оноос 2.05 хувь буюу 1.2 сая ам.доллар/тн-оор буурсан хэдий ч алтны экспортын биет хэмжээ 14.3 хувиар нэмэгдсэн нь алтны экспортын орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна. Алтны экспортын орлого нэмэгдсэн нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, гадаад валютын ханшийг тогтвортой байлгахад эерэг нөлөөтэй юм.

Дараах эрдэс бүтээгдэхүүний экспортын орлого өмнөх онтой харьцуулахад буурсан байна. Үүнд:

Зэсийн баяжмал: 2021 онтой харьцуулахад зэсийн баяжмалын экспорт 170.8 мянган тонноор өсч, үнийн дүн нь 165.0 сая ам.доллараар, хилийн дундаж үнэ нь 379.2 ам.доллараар тус тус буурчээ. 2022 оны эхний 12 сард зэсийн баяжмалыг 100.0 хувь БНХАУ-д экспортолсон байна.

Төмрийн хүдэр: 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.7 сая тонн төмрийн хүдэр экспортолж, 391.0 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оноос 58.9 хувь буюу 561.2 сая ам.доллараар буурахад төмрийн хүдрийн биет хэмжээ 33.4 хувь буюу 2.4 сая тонноор буурсан, мөн нэг тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 82.6 ам.доллар болж өнгөрсөн оноос 51.4 ам.доллар/тн-оор буурснаас гадна хил гааль, тээвэр логистикийн хүндрэлтэй нөхцөл байдал зэрэг нь нөлөөлсөн байна. Төмрийн хүдрийг 100.0 хувь БНХАУ-д экспортолсон байна.

Катодын зэс буюу тунгаасан зэс ба хайлш: 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 10 мянган тонн катодын зэс экспортолж, 82.6 сая ам.долларын орлого олсон бөгөөд экспортын орлого нь өмнөх оноос 6.7 хувь буюу 6.0 сая ам.доллараар буурсан. Нэг тонн тунгаасан зэсийн экспортын дундаж үнэ 8.2 хувиар буурсан нь экспортын орлогын бууралтад нөлөөлсөн байна.

Боловсруулагүй нефть: 2022 оны эхний 12 сард боловсруулагүй нефтийн экспорт 2,605.7 мянган баррель буюу 241.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 1,743.2 мянган баррелиар, үнийн дүнгээр 31.5 сая ам.доллараар тус тус буурсан байна. 1 баррель нефтийн дундаж үнэ 62.9 ам.доллараар 92.8 ам.доллар болж өсжээ.

Нийт экспортын орлогын 51.8 хувийг нүүрс, 21.8 хувийг зэсийн баяжмал, 8.9 хувийг алт, 3.1 хувийг төмрийн баяжмал, 2.3 хувийг цайрын баяжмал эзэлсэн байна. 2022 оны эрдэс бүтээгдэхүүний экспортын 82.5 хувийг чулуун нүүрс, зэсийн баяжмал, молибдены баяжмал, хайлуур жонш, төмрийн хүдэр, цайрын хүдэр болон боловсруулагүй нефтийн экспорт эзэлж байна.

3.3. Импорт:

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нийт импортын худалдаа 8,704.4 сая ам.долларт хүрч өнгөрсөн оноос 27.2 хувь буюу 1,859.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт импортын 22.5 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 77.5 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,960.3 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 621.7 сая ам.доллараар буюу 46.4 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 6,744.1 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 1,237.2 сая ам.доллар буюу 22.5 хувиар өсжээ.

Хүснэгт 16. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

| Үзүүлэлт | Он | | | | | Өөрчлөлт | | Нийт импортод эзлэх хувь |
|-------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|-------------|--------------------------|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | Дүн | Хувь | |
| Эрдсийн бүтээгдэхүүний импорт | 1,325.8 | 1,372.3 | 1,007.2 | 1,338.6 | 1,960.3 | 621.7 | 46.4 | 22.5 |
| Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт | 4,549.0 | 4,755.1 | 4,291.7 | 5,506.9 | 6,744.1 | 1,237.2 | 22.5 | 77.5 |
| Нийт импорт | 5,874.8 | 6,127.4 | 5,298.9 | 6,845.5 | 8,704.4 | 1,859.0 | 27.2 | 100 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Импортоор нийлүүлэгдсэн барааны нийт дүнд эрдэс бүтээгдэхүүн 22.5 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 14.5 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 9.0 хувь, авто агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги 19.5 хувь, хуванцар болон хуванцар эдлэл, хаймар түүгээр хийсэн эдлэл 4.0 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.3 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 6.9 хувийг тус тус эзэлж, эдгээр бүтээгдэхүүн нийт дүнгийн 85.7 хувийг эзэлж байна.

2022 оны байдлаар импортын 31.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 38.0 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 11.0 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 20.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлсэн байна.

Хүснэгт 17. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/


| Бүтээгдэхүүн | Он | | | | | | Өөрчлөлт (Сая ам.дол) |
|---|----------------|--------------|----------------|--------------|----------------|--------------|--------------------------|
| | 2020 | | 2021 | | 2022 | | |
| | Сая ам.дол | Эзлэх хувь | Сая ам.дол | Эзлэх хувь | Сая ам.дол | Эзлэх хувь | 2022/2021 |
| Хэрэглээ | 1,542.0 | 29.0 | 2,184.0 | 32.0 | 2,686.0 | 31.0 | 502.0 |
| - Түргэн эдэлгээтэй | 878.0 | 17.0 | 1,315.0 | 19.0 | 1,501.0 | 17.0 | 186.0 |
| - Удаан эдэлгээтэй | 664.0 | 13.0 | 869.0 | 13.0 | 1,185.0 | 14.0 | 316.0 |
| Хөрөнгө оруулалт | 2,290.0 | 43.0 | 2,757.0 | 40.0 | 3,308.0 | 38.0 | 551.0 |
| - Машин, механик тоног төхөрөөмж, эд анги | 1,419.0 | 27.0 | 1,768.0 | 26.0 | 1,987.0 | 23.0 | 219.0 |
| - Барилгын материал | 599.0 | 11.0 | 727.0 | 11.0 | 1,002.0 | 12.0 | 275.0 |
| - Хөрөнгө оруулалтын бусад бараа | 272.0 | 5.0 | 262.0 | 4.0 | 318.0 | 4.0 | 56.0 |
| Аж үйлдвэрлэлийн орц | 634.0 | 12.0 | 762.0 | 11.0 | 966.0 | 11.0 | 204.0 |
| - Химийн бүтээгдэхүүн | 110.0 | 2.0 | 134.0 | 2.0 | 252.0 | 3.0 | 118.0 |
| - Цахилгаан эрчим хүч | 142.0 | 3.0 | 161.0 | 2.0 | 182.0 | 2.0 | 21.0 |
| Нефтийн бүтээгдэхүүн | 817.0 | 15.0 | 1,132.0 | 17.0 | 1,724.0 | 20.0 | 592.0 |
| - Дизель | 432.0 | 8.0 | 590.0 | 9.0 | 960.0 | 11.0 | 370.0 |
| - АИ-92, 95 | 222.0 | 4.0 | 353.0 | 5.0 | 535.0 | 6.0 | 182.0 |
| - А80 ба бусад | 163.0 | 3.0 | 189.0 | 3.0 | 228.0 | 3.0 | 40.0 |
| Нийт дүн | 5,298.9 | 100.0 | 6,845.5 | 100.0 | 8,704.4 | 100.0 | 1,859.0 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 онтой харьцуулахад 2022 онд импортын худалдаа 1,859.0 сая ам.доллараар нэмэгдэхэд хэрэглээний бүтээгдэхүүн 502.0 сая, нефтийн бүтээгдэхүүн 592.0 сая, хөрөнгө оруулалт 551.0 сая, аж үйлдвэрийн орц 204.0 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Импорт бүх төрлөөр нэмэгдсэн байна. Ялангуяа дизель түлш 370.0 сая ам.доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 316.0 сая ам.доллар, барилгын материал 275.0 сая, машин, тоног төхөөрөмж 219.0 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь нийт импортын өсөлтийн 63.5 хувийг эзэлж байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оноос 592.0 сая ам.доллараар өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт нөлөөлжээ. Дизель түлшний импорт 370.0 сая ам.доллар, бензин 282.0 сая ам.доллараар нэмэгджээ. 2022 оны эцэст нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 131.9 ам.дол/баррель болсон байна. Энэ нь 2021 оны жилийн эцсээс 46.7 хувиар өссөн үзүүлэлт юм.

График 12. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Мөнгөний нийлүүлэлт:

Мөнгөний нийлүүлэлт 2022 оны эцэст 29,664.8 тэрбум төгрөг болж 2021 оноос 1,801.3 тэрбум төгрөг буюу 6.5 хувиар өссөн байна.

2021 оноос мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бусад харилцах 1,107.2 тэрбум төгрөг буюу 5.2 хувь, М1 мөнгө 694.1 тэрбум төгрөг буюу 10.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин төгрөгийн хадгаламж 16.1 хувь буюу 2,416.4 тэрбум төгрөгөөр буурсан байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар гадаад валютын харилцах 4,946.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 2.1 дахин нэмэгдэж, гадаад валютын хадгаламж 773.1 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 18. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | Оны эцсийн байдлаар | | | Өөрчлөлт (+/-) | |
|---------------------------------|---------------------|-----------------|-----------------|----------------|------------|
| | 2020 | 2021 | 2022 | 2022/2021 | |
| | | | | Дүн | Хувь |
| Мөнгөний нийлүүлэлт (M2) | 24,480.7 | 27,863.5 | 29,664.8 | 1,801.3 | 6.5 |
| Бусад харилцах | 20,268.4 | 21,356.3 | 22,463.5 | 1,107.2 | 5.2 |
| -Төгрөгийн хадгаламж | 13,514.8 | 15,006.6 | 12,590.2 | -2,416.4 | -16.1 |
| -Валютын хадгаламж | 4,684.2 | 3,921.1 | 4,694.2 | 773.1 | 19.7 |
| -Валютын харилцах | 1,997.0 | 2,344.5 | 4,946.8 | 2,602.3 | 111.0 |
| М1 мөнгө | 4,212.4 | 6,507.2 | 7,201.3 | 694.1 | 10.7 |

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны эцсийн байдлаар 22.0 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны эцсээс 1.3 их наяд төгрөг буюу 6.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 19. Зээлийн өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | Он | | | Өөрчлөлт (+/-) | |
|---|----------------|-----------------|-----------------|----------------|-------------|
| | | | | 2022/2021 | |
| | 2020 | 2021 | 2022 | Дүн | Хувь |
| Зээлийн өрийн үлдэгдэл | 7,034.2 | 20,667.4 | 22,008.3 | 1,340.9 | 6.5% |
| -Хэвийн зээл | 15,456.5 | 19,149.8 | 20,727.5 | 1,577.6 | 8.2% |
| -Хугацаа хэтэрсэн зээл | 1,264.5 | 932.5 | 1,123.5 | 190.9 | 20.5% |
| -Чанаргүй зээл | 2,002.3 | 2,073.1 | 2,018.9 | -54.2 | -2.6% |
| Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх % | 11.8% | 10.0% | 9.2% | - | - |
| Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх % | 7.4% | 4.5% | 5.1% | - | - |

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 51.9 хувь нь иргэдийнх, 46.0 хувь нь хувийн байгууллагынх, 1.3 хувь нь төрийн байгууллагынх, 0.8 хувь нь санхүүгийн болон бусад байгууллагынх байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2022 оны эцэст 1,123.5 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны эцсээс 190.9 тэрбум төгрөг буюу 20.5 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.1 хувийг эзэлж, 2021 оноос 0.6 нэгж хувиар өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2022 оны эцэст 2.0 их наяд төгрөг болж, өнгөрсөн оноос 54.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.2 хувийг эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.8 нэгж хувиар буурчээ.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2022 онд 551.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 600.2 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оноос гүйлгээ 616.4 (52.8%) тэрбум төгрөгөөр, арилжсан үнэт цаас 91.3 (13.2%) сая ширхгээр буурчээ. Үнэт цаасны гүйлгээ 2022 оны 12 дугаар сард 170.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 157.2 (12.9 дахин) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 138.7 (5.4 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ. Арилжсан үнэт цаас 133.8 сая ширхэг болж, өмнөх сараас 106.8 (5.0 дахин) сая ширхгээр, өмнөх оноос 121.3 (10.7 дахин) сая ширхэгээр өссөн байна.


Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2022 оны 12 дугаар сард 6.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 1.4 (25.8%) их наяд төгрөгөөр, өмнөх оноос 909.3 (13.2%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2022 оны 12 дугаар сард 36,176.8 нэгж болж, өмнөх сараас 1,854.0 нэгжээр өсөж, өмнөх онтой харьцуулахад 5,492.0 нэгжээр буурсан байна.

Валютын ханш: 2022 оны жилийн эцэст Монголбанкны төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн сарын дундаж 3,431.3 төгрөг болж, өмнөх оноос 582.3 төгрөгөөр суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 491.7 төгрөг болж өмнөх оноос 44.3 төгрөгөөр суларчээ.

График 13. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юанийн сарын дундаж ханш, 2022 оны жилийн эцсийн байдлаар /төгрөгөөр/

График 15. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юаны сарын дундаж ханш, 2022 оны жилийн эцсийн байдлаар, төгрөгөөр




Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс:

Хэрэглээний үйлчилгээний үнэ 2022 оны 12 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оноос 13.2 хувь, өмнөх сараас 1.0 хувиар өссөн байна.

Дэлхийн ихэнх улс орнуудад үүсээд байсан тээвэрлэлтийн гацаа, нийлүүлэлтийн саатлууд сүүлийн саруудад намжиж, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт буурсан ч хүнсний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлчилгээний үнэ өссөөр байгаа нь инфляц үргэлжлэн өсөхөд голлон нөлөөлж байна. Манай улсын хувьд нэг талаас гадаад орчны таагүй нөхцөл байдал үргэлжлэх, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх, зээл, санхүүжилтийн эх үүсвэр хумигдах зэрэг үйл явц эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлөх хандлагатай байгаа бол нөгөө талаас хүнсний үнэ өсөх, нийлүүлэлтийн буюу зардлын шалтгаантай инфляц удаан хугацаанд үргэлжлэх эрсдэл тулгарч байна.

График 14. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, сар бүрийн өөрчлөлт/хувиар/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

4.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2022 оны эцэст 3,399.6 сая ам.доллар болж өнгөрсөн онтой харьцуулахад 966.5 сая ам.доллар буюу 22.1 хувиар буурсан хэдий ч 2022 оны 8 дугаар сараас 26.1 хувь буюу 704.0 сая ам.доллароор өссөн байна. 2022 оны 8 дугаар сард гадаад валютын албан нөөц 2,695.6 сая ам.доллар болж, 2022 оны хамгийн бага түвшинд хүрсэн.

График 15. Нийт гадаад валютын албан нөөц (сая ам.доллароор)



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2022 оны эцэст 3,399.6 сая ам.доллар болж импортын 4.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Өнгөрсөн онтой харьцуулахад импортын хэмжээ өссөн, гадаад валютын албан нөөц буурсан зэрэг нь импортын хэрэгцээг хангах түвшнийг бууруулахад нөлөөлсөн байна.

Хүснэгт 20. Гадаад валютын албан нөөц ба импорт


/сая ам.доллар/

| № | Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|--|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| 1 | Нийт импорт | 5,875.0 | 6,128.0 | 5,299.0 | 6,846.0 | 8,704.0 |
| 2 | Гадаад валютын нийт нөөц | 3,549.1 | 4,348.6 | 4,534.1 | 4,366.1 | 3,399.6 |
| 3 | Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/ | 7.2 | 8.5 | 10.3 | 7.6 | 4.6 |

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2022 оны байдлаар 22.9 тонн болж, 2021 оноос 2.1 тонн буюу 10.0 хувиар нэмэгдсэн байна. 2019 оныг тооцохгүй бол 2017-2022 онд Монголбанк нь жилд 20.0 тонноос дээш хэмжээгээр алт худалдан авсан байна. Ялангуяа сүүлийн 3 жилд худалдан авсан алтны хэмжээ өндөр байжээ.

График 16. Алтны хэмжээ, 2012-2022 оноор /тонноор/



Эх сурвалж: Монголбанк

4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 2,653.4 сая ам.долларын алдагдалтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 750.9 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оноос 529.3 сая ам.долларын алдагдалтай гарч, төлбөрийн тэнцэл муудсан байна.

2022 оны байдлаар урсгал тэнцлийн алдагдал 2,653.4 сая ам.доллар байна. Хэдийгээр хоёрдогч орлого 445.0 сая ам.долларын ашигтай гарсан ч гэсэн урсгал тэнцлийн хувьд бараа ба үйлчилгээний худалдааны тэнцэл 1,094.9 сая ам.долларын, мөн анхдагч орлого 2,003.6 сая ам.долларын алдагдалтай тус тус гарсан нь урсгал тэнцэл алдагдалтай гаргахад нөлөөлсөн байна.

2022 оны байдлаар хөрөнгийн тэнцэл 162.7 сая ам.долларын, санхүүгийн тэнцэл 2,715.3 сая ам.долларын ашигтай гарсан байна. Төлбөрийн тэнцэл 750.9 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оноос 529.3 сая ам.доллароор нэмэгдсэн байна.

Хүснэгт 21. Төлбөрийн тэнцэл, 2020-2022 оны байдлаар

/сая ам.доллар/

| Үзүүлэлт | Жилийн эцсийн гүйцэтгэл | | | Өөрчлөлт (2022/2021, +/-) | |
|------------------------------------|-------------------------|-----------------|-----------------|---------------------------|-------------------|
| | 2020 | 2021 | 2022 | Дүн | Хувь |
| I. Урсгал Тэнцэл | -674.6 | -2,108.4 | -2,653.4 | -545.0 | 25.8 |
| А. Бараа ба үйлчилгээний худалдаа | 305.3 | -305.7 | -1,094.9 | -789.2 | -2.5 дахин |
| В. Анхдагч орлого | -1,253.3 | -2,231.8 | -2,003.6 | 228.2 | -10.2 |
| С. Хоёрдогч орлого | 273.3 | 429.1 | 445.0 | 15.9 | 3.7 |
| II. Хөрөнгийн тэнцэл | 102.8 | 114.0 | 162.7 | 48.7 | 42.7 |
| III. Санхүүгийн тэнцэл | -1,504.2 | -1,982.2 | -2,715.3 | -733.1 | 37.0 |
| IV. Алдаа болон орхигдуулга | -145.6 | -209.4 | -224.6 | -15.2 | 7.3 |
| Төлбөрийн тэнцлийн нийт дүн | 786.9 | -221.9 | -750.9 | -529.3 | -2.3 дахин |

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


5.1. Хүн ам, ажил эрхлэлт

2022 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 67.8 мянган хүүхэд шинээр төрж, төрсөн хүүхэд өмнөх оноос 5.9 мянгаар буурчээ. 2022 оны 12 сарын эцсийн гүйцэтгэлээр нийт ажиллах хүчний тоо 1,222.9 мянга байна. Ажиллах хүчнээс 1,158.2 мянган хүн нь ажилтай, 64.6 мянган иргэд нь ажилгүй хүмүүс байна. Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 57.9 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.9 хувьтай байна. Мөн 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 888.1 мянга байна. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхжлийг илэрхийлэх үзүүлэлт болох ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 0.4 нэгж хувиар буурсан байна.

5.2. Ажилгүйдлийн түвшин

2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 5.3 хувьтай болж, өнгөрсөн оноос 2.8 нэгж хувиар буурсан байна.

График 17. Ажилгүйдлийн түвшин /хувиар/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС